

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1 “Алсын хараа 2050”-ын 5.3 дугаар зорилт. Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.

5.3.11.Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Нийслэлээс иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлдэг нийт 589 төрлийн үйлчилгээ байдаг. Үүнээс 225 нь зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй үйлчилгээнүүд байдаг. Тэдгээрийг авахад олон шат дамжлагатай, бүрдүүлэх бичиг баримт их, мэдээ, мэдээлэл хангалтгүй, зөвшөөрөл олгох хүсэлтийн хариу удаан, очер дараалал ихтэй зэрэг бэрхшээлүүдээс үүдэн иргэн, аж ахуй нэгж байгууллагууд төрийн үйлчилгээг авахдаа сэтгэл ханамжгүй байдал үүсч, авилга хүнд суртал үүсэх шалтгаан болоод байсан. (ажлын 7-30 хоногт авдаг байсан)

Дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимжуулахаар “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд дүүргүүдийн худалдаа үйлчилгээний хэлтсээс иргэн, аж ахуйн нэгжид олгодог үйл ажиллагаа эрхлэх 83 нэр төрлийн зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийн бүрдэл бичиг баримт, шат дамжлагыг багасган цахимжуулж 5 минутын дотор үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.

2022 оны жилийн эцсийн 275186 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 7810 хүсэлтийг ирүүлснээс 6061 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. Мөн Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас олгодог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 29 тусгай зөвшөөрлийг цахимжуулсан.

Ингэснээр нийслэл хотод худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа 18,664 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дараах бодит үр дүн, хэмнэлт гарсан.

- 167,976 баримт бичиг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шаардахгүй болсон.
- 191,306,000 төгрөгийн бичиг хэргийн болон тээврийн зардлыг хэмнэж байна.
- 447,936 цагийг хэмнэх боломж бүрдсэн.

1.2 Төрөөс баримтлах бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг 2021 оны “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон болно.

1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд хамтран хэрэгжүүлэх 5 арга хэмжээнээс 2 арга хэмжээний хугацаа болоогүй, 2 арга хэмжээ НГЗБА, НХБХГ-ууд дээр хийгдэж байгаа, 1 арга хэмжээ 100% хэрэгжсэн.

Д/д	Бодлого чиглэл	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
1	Гурав. Эдийн засгийн бодлого	3.7.2.5 Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	НГЗБА, НХБХГ-уудад хийгдэж байгаа болно.
2		3.7.3.2 Хиймэл оюун ухаан, блокчейн болонгазар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлнэ.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар дээр хийгдэж байгаа болно.
3		3.7.3.3 Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	НГЗБА, НХБХГ дээр хийгдэх ажил болно.
4		3.7.3.5 Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно.	НГЗБА, НХБХГ-уудад хийгдэж байгаа болно.
5	Дөрөв. Засаглалын бодлого	4.1.3.3 Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Нийслэлийн нутгийн захиргааны 20 байгууллагын 133 төрлийн үйлчилгээг Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia систем рүү бүрэн шилжүүлсэн.

1.4 Улс болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Байгууллагын хэмжээнд 2022 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 8 төсөл арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ 100%, 4 төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосон.

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэл
1	“Иргэн аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал” e-mongolia системд холбох	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж худалдан авах ажиллагааг зарласан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосонтой
2	“Call center дуудлагын төвийг өргөжүүлж, дахин загварчлан сайжруулах ажил”	
3	“Нийслэлийн Хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн баяжуулалт”	
4	“Нийслэлийн татвар, төлбөр, хураамжийн нэгдсэн тогтолцоо” дэд төсөл хэрэгжүүлэх	
5	Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем	100%
6	“Онлайн бизнес төв” дэд төсөл хэрэгжүүлэх	100%
7	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP системийн нэмэлт хөгжүүлэлт	100%
8	Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем	100%

1.5 Бүсчилсэн хөгжлийн бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичиг батлагдаагүй болно.

1.6 Үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон.

1.7 Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/04 дугаар тогтоолоор батлагдсан нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын 14.7 Мэдээлэл, холбооны технологийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Нийслэлээс үзүүлж буй төрийн үйлчилгээнд шинэ менежментийг нэвтрүүлж нийслэлийн цахим үйлчилгээний E-SERVICE системийг 2018 онд хэрэглээнд нэвтрүүлж нийслэлийн 20 байгууллагын 123 үйлчилгээг цахимаар үзүүлж нийслэлийн төрийн байгууллагуудын үйлчилгээг цахимжуулсан нь богино хугацаанд нийслэлийн иргэдийн хэрэглээнд амжилттай нэвтэрч, гарч буй эерэг үр дүн, туршлага нь Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн E-MONGOLIA системийн сайн туршлага болсон.

Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимжуулахаар “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд дүүргүүдийн худалдаа үйлчилгээний хэлтсээс иргэн, аж ахуйн нэгжид олгодог үйл ажиллагаа эрхлэх 83 нэр төрлийн зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийн бүрдэл бичиг баримт, шат дамжлагыг багасган цахимжуулж 5 минутын дотор үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.

2022 оны жилийн эцсийн байдлаар 275186 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 7810 хүсэлтийг ирүүлснээс 6061 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. Мөн Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас олгодог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 29 тусгай зөвшөөрлийг цахимжуулсан.

Нийслэлийн нийт өрхөд интернет холбогдсон өрхийн эзлэх хувь:

Нийслэлийн 9 дүүргийн 151 хороо, Сонгинохайрхан болон алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн ЗДТГ-ын байрны гадна талбайд цацсан утасгүй интернетийн үйлчилгээний байнгын хэвийн ажиллагааг хангаж, хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд хүн ам ихээр төвлөрдөг номын сан, амралт зугаалгын бүсийн судалгааг гаргаж нийт 35 байршилд шинээр утасгүй интернетийн үйлчилгээг хүргэхээр тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг гаргасан. Үүнд: Богд хааны ордон музей, Гандантэгчилэн хийд, УБ төмөр замын буудал, Хүүхдийн урлан бүтээх төв, Жуковын хөшөө, музей, Монгол цэргийн музей, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Улсын төв номын сан, Улсын төв номын сангийн салбарууд, Налайх дүүргийн Соёлын ордон Багахангай дүүргийн соёлын ордон гэх мэт байршилд суурилуулах техникийн даалгавар боловсруулагдсан бөгөөд төсвийн асуудал шийдвэрлэгдээгүй тул төлөвлөсөн ажил хүлээгдэж байна.

1.8 Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 3 зорилтын 6 арга хэмжээ, 2022 ооны төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэх 3 зорилтын 10 арга хэмжээнээс 70 хувьтай хэрэгжсэн 1 арга хэмжээ, 50 хувьтай хэрэгжсэн 8 арга хэмжээ, 30 хувьтай 1 төсөл, арга хэмжээ байна.

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хувь
Зорилт 5.2. Нийслэл хот хяналт удирдлагын цогц систем бий болгож, нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгосон байна.		
1	5.2.1. Нийслэлийн алслагдсан 3 дүүргийг цахим мэдээллийн нэгдсэн сан, сүлжээнд холбож, дэд бүтэц сайжирсан байна.	100%
2	5.2.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна.	100%
3	5.2.4. Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн ам ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернетжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	50%
Зорилт 7.3. Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор камерын нэгдсэн хяналтын системийг бий болгоно.		
4	7.3.1. Нийслэлийн удирдлага, хяналтын цогц системийг байгуулж хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	100%
5	7.3.2. Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглал /Griemmar, Compstat/-ыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, Улаанбаатар хотын хэмжээнд ашиглагдаж буй хяналтын камерыг “Камерын удирдлагын нэгдсэн төв”-тэй холбож, гудамж, зам талбайн хяналт, гэмт хэрэг илрүүлэлт сайжруулж, гэмт хэргийн гаралт бууруулсан байна.	100%
Зорилт 9.20. Авто замын хөдөлгөөний төлөвлөлтийг оновчтой түвшинд төлөвлөж, авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулна.		
6	9.20.2. “Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем” төслийг бүрэн хэрэгжүүлсэн байна.	70%
Хэрэгжилтийн дундаж хувь		86,6%

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилт **90%** байна.

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хувь
1	4.1.3.1 Харилцаа холбоо, мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн төвтэй, ухаалаг үйлчилгээг үзүүлэх “Цахим засаглал хөтөлбөр” хэрэгжүүлнэ.	100%
	4.1.3.2 Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн ам ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернетжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	50%
2	4.2.1.2 Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрлийн тоог цөөрүүлж,	100%

	зөвшөөрөл олгох нөхцөл журмыг тодорхой ойлгомжтой болгон цахимжуулж, хяналт шалгалтыг цөөрүүлнэ.	
3	4.3.1.1 Нийслэлийн удирдлага хяналт, зохицуулалтын нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	100%
4	4.3.1.2 Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр програм хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглалыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, камерыг “Камерын удирдлагын нэгдсэн төв”-тэй холбоно.	100%
5	6.3.11.3 Замын хөдөлгөөнийг удирдах, хянах, бүртгэх үйл ажиллагааны нэгдсэн ухаалаг дэд системүүдийг нэвтрүүлнэ.	100%
Хэрэгжилтийн дундаж хувь		90%

ХОЁР.ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

2.1 УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

Байгууллагын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналтад байгаа 4 тогтоол, шийдвэрийн 7 заалтын хэрэгжилтийг тооцож даргын зөвлөлийн хуралд танилцуулж удааширсан арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан бөгөөд байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой тогтоол шийдвэр /Ерөнхийлөгчийн зарлиг 2, Засгийн газрын тогтоол 5, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 8, Засгийн газрын албан даалгавар 5 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол 1/-үүдийн хэрэгжилтийг нэгтгэн хяналт шинжилгээ үнэлгээ хийж хэрэгжилт **97,5** тай байна.

2.2 Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын холбогдолтой мэдээлэл

Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимжуулахаар “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд дүүргүүдийн худалдаа үйлчилгээний хэлтсээс иргэн, аж ахуйн нэгжид олгодог үйл ажиллагаа эрхлэх 83 нэр төрлийн зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийн бүрдэл бичиг баримт, шат дамжлагыг багасган цахимжуулж 5 минутын дотор үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.

2022 оны жилийн эцсийн байдлаар 275186 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 7810 хүсэлтийг ирүүлснээс 6061 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. Мөн Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас олгодог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 29 тусгай зөвшөөрлийг цахимжуулсан.

Мөн үндэсний их баяр наадмын үеэр үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн шинжтэй 3 төрлийн 9 үйлчилгээг цахимжуулахаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан бөгөөд үйлчилгээний

бүртгэлийг 2022 оны 06 дугаар сарын 29-нөөс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан, Улсын баяр наадмын үеэр 2 байршилд 3 үйлчилгээний төрөл, 9 чиглэлийн дагуу иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас хүсэлтийг хүлээн авсан бөгөөд Төв цэнгэлдэх 344, Хүй долоо худагт 243 хүсэлтүүд ирсэн байна. Үүнээс хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр 255, хүнсний худалдааны чиглэлээр 157, Хүнснээс бусад худалдааны чиглэлээр 138, хөдөлгөөнт тоглоомын үйлчилгээний чиглэлээр 26, бэлэг дурсгалын худалдааны чиглэлээр 9, явуулын кофены үйлчилгээний чиглэлээр 2 хүсэлтүүдийг бүртгэж хүлээн авсан.

ОНЛАЙН БИЗНЕС ТӨВ
Нэвтрэх

БҮХ ҮЙЛЧИЛГЭЭ 83

- Худалдаа 18
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ 14
- Ахуйн үйлчилгээ 20
- Зочлох үйлчилгээ 5
- Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ 5
- Авто үйлчилгээ 6
- Тоглоомын төв 2
- Соёл урлагийн үйлчилгээ 2
- Үйлдвэрлэл 2
- Наадам - Төв цэнгэлдэх 3**
- Наадам- Хүй 7 худаг 6

Баяр наадмын үеэр үйлчилгээ эрхлэх хүсэлт хүлээн авах хугацаа 7-р сарын 1-ний өдрийн 17:00 цагт дуусна.

Үйлчилгээний горим

Үйлчилгээний төрөл

Төлбөр

Үйлчилгээний нэр

НААДАМ - ТӨВ ЦЭНГЭЛДЭХ

Хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх (Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүрэг)
✔ Идэвхтэй

Хүнсний худалдаа эрхлэх (Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүрэг)
✔ Идэвхтэй

Хүнснээс бусад худалдаа эрхлэх (Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүрэг)
✔ Идэвхтэй



ХОЛБОО БАРИХ

☎ 1800-1200
 ✉ support@ulaanbaatar.mn
 📍 МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, ЖАНЖИН Д. СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ТАЛБАЙ 7, ХАНГАРЬД ОРДОН

ХАНДАЛТЫН ТОО

Энэ долоо хоногт: **14799**
 Энэ сард: **38090**
 Нийт: **153290**

Зураг 1. Төв цэнгэлд гарах үйлчилгээ

Ахуйн үйлчилгээ 20

- Зочлох үйлчилгээ 5
- Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ 5
- Авто үйлчилгээ 6
- Тоглоомын төв 2
- Соёл урлагийн үйлчилгээ 2
- Үйлдвэрлэл 2
- Наадам - Төв цэнгэлдэх 3
- Наадам- Хүй 7 худаг 6**

НААДАМ- ХҮЙ 7 ХУДАГ

Хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх (Сонгинохайрхан, Баянгол дүүрэг)
✔ Идэвхтэй

Хүнсний худалдаа эрхлэх (Сонгинохайрхан, Баянгол дүүрэг)
✔ Идэвхтэй

Хүнснээс бусад худалдаа эрхлэх
✔ Идэвхтэй

Соёл урлагийн талбайд гар урлал бэлэг дурсгал, соёлын барааны худалдаа эрхлэх
✔ Идэвхтэй

Соёл урлагийн талбайд хөдөлгөөнт тоглоомын үйлчилгээ эрхлэх
✔ Идэвхтэй

Соёл урлагийн талбайд явуулын үйлчилгээтэй кофены цэг ажиллуулах
✔ Идэвхтэй

Зураг 2. Хүй 7-д гарах үйлчилгээ

Зураг 3. Зөвхөн ААН хүсэлт гаргах үйлчилгээний Иргэн/Хуулийн этгээдийн алхамын дэлгэц

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

4.1. Нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудаас үзүүлдэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний нэгдсэн платформыг хөгжүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх

Нийслэлийн салбар бүрт мэдээллийн технологийн шийдлүүдийг ашиглан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалыг сайжруулах, иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлэх төрийн үйлчилгээний шат дарааллыг багасгах, үйлчилгээг цахимжуулах, нийслэлийн харьяа газруудын үйл ажиллагаандаа ашиглаж буй мэдээллийн системийг дахин төлөвлөх, орчин үеийн ухаалаг нэгдсэн системд шилжүүлэх Улаанбаатар хотын “Нэг тархи нэгдсэн систем” төслийг боловсруулан 2020-2024 онд хэрэгжүүлэхээр үндэсний мэдээллийн технологийн салбарын компаниудтай хамтран 2022-2024 онд хэрэгжүүлэхээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай санамж бичгийг байгуулсан бөгөөд 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/912 дугаар захирамжаар батлуулсан.

Үндэсний мэдээллийн технологийн салбарын 70 гаруй компаниудтай хамтран 2022-2024 онд хэрэгжүүлэх “УЛААНБААТАР ХОТЫН ЦАХИМ ШИЛЖИЛТ”-ийн төлөвлөгөөг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагууд болон төрийн албан хаагчдад таницуулах арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10:00 цагт Яармаг дахь Хангарьд ордны хүндэтгэлийн танхимд зохион байгуулсан.



“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газраас дэвшүүлсэн Цахим үндэстэн болох зорилт, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хүрээнд төрийн үйлчилгээний шат дараалал, авлига хүнд суртал, авто замын түгжрэл, агаарын бохирдол, иргэдийн аюулгүй байдал зэрэг Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудлуудыг технологийн тусламжтайгаар шийдвэрлэхээр үндэсний мэдээллийн технологийн тэргүүлэх компаниудтай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийн үр өгөөжийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Хангарьд ордны Нийслэлийн Засаг захиргааны II байрны 14 давхрын Их танхимд зохион байгуулж УИХ болон Засгийн газрын гишүүд, НИТХ-ын төлөөлөгч нар болон сэтгүүлчдэд танилцуулсан.

Улаанбаатар хотын “Дижитал шилжилт”-ийн төлөвлөгөөг олон улсын жишиг, өөрийн орны онцлог, иргэдийн соёл уламжлал, байгаль орчны эрс тэс уур амьсгал, төрийн байгуулалтын онцлогт тулгуурлан Цахим засаглал, Зам, тээврийн нэгдсэн ухаалаг систем, Аюулгүй хот гэсэн гурван дэд бүлэг,

- Замын хөдөлгөөний менежментийг сайжруулах
- Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Төрийн албаны хяналт, хариуцлагыг сайжруулах
- Хөрөнгө оруулалт, төсвийг нэмэгдүүлэх
- Авлига, хүнд суртлыг бууруулах

Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх гэсэн зургаан зорилттойгоор боловсруулан, хэрэгжүүлж эхлээд байна.



Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимжуулахаар “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд дүүргүүдийн худалдаа үйлчилгээний хэлтсээс иргэн, аж ахуйн нэгжид олгодог үйл ажиллагаа эрхлэх 83 нэр төрлийн зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийн бүрдэл бичиг баримт, шат дамжлагыг багасган цахимжуулж 5 минутын дотор үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 275186 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 7810 хүсэлтийг ирүүлснээс 6061 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна.

Мөн Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас олгодог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 29 тусгай зөвшөөрлийг цахимжуулсан.


Нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудаас үзүүлдэг үйлчилгээг ил тод хүргэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд Нийслэлийн мэдээ, мэдээллийн <https://www.ulaanbaatar.mn/> цахим хуудасны 2.0 хувилбарыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Англи хэл дээр ашиглах боломжтой байдлаар боловсруулан хэрэглээнд нэвтрүүлсэн.

Тус цахим хуудсанд хагас жилийн байдлаар нийт 360 гаруй цаг үеийн мэдээ, 130 гаруй тогтоол, захирамж, шийдвэрүүд, 15 удаагийн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар

хотын захирагчаас өгсөн Шуурхайн үүрэг даалгаврууд болон бусад холбогдох мэдээ мэдээлэл, видео, шторкууд орсон бөгөөд нийт хандалтын тоо **247,758** байна. Мөн <https://www.ulaanbaatar.mn/> цахим хуудсаар 3 удаагийн санал асуулга явагдсан байна.

Үүнд:

1. Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнд авсан санал асуулга
2. Хотын стандартын 33 төсөлд авсан санал асуулга
3. Нийслэлийн ерөнхий боловсролын зарим сургуулийн хичээл эхлэх, тарах цагийг зөрүүлэх санал асуулга



4.2.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэл түүний харьяа газруудад мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зөвлөмж өгч, хяналт тавьж, хүлээн авч ажилласан. Үүнд:

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд дотоод удирдлагын UBERP системээр дамжуулан Нийслэлийн нутгийн захиргааны II байр буюу Хангарьд ордны хурлын заалтай танилцан, захиалга хийх “Хурлын заал захиалах” систем нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.
- “Их өгөгдлийн сан бүхий орон зайн дүн шинжилгээний төв байгуулах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэж, өгөгдлүүдийг боловсруулан, бодит цаг хугацааны хяналтын самбарын II шатны хөгжүүлэлт” зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд Нийслэлийн орон зайн дүн шинжилгээний төвийн хяналтын дашбоардуудыг дундын мэдээллийн сан дээр байршуулан ажиллуулах юм.

- “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийн нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлтийн ажил дууссан бөгөөд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын тайлан мэдээ болон хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд системийн ашиглалтын сургалтуудыг НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн албан хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

- “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль, “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай” хууль, “Кибер аюулгүй байдлын тухай” хууль, “Цахим гарын үсгийн тухай” хуулиуд 2022 оны 05 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан дагалдан гарч байгаа дараахь журмын төслүүдэд холбогдох саналуудыг боловсруулан дээд газарт хүргүүлж ажилласан.

1. Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журмын төсөл;
2. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөх үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмын төсөл;
3. Цахим хуудас хөтлөх, ил тод нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмын төсөл;
4. Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хийх журмын төсөл;
5. Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглах журам;
6. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журмын төсөл;
7. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журмын төсөл;
8. Хязгаарлалтай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журмын төсөл;

4.3. Газрын хариуцсан програм хангамж, системийн ашиглалтыг сайжруулж системийн хөгжүүлэлт, найдвартай ажиллагааг хангах

Нийслэлийн хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн доорх системүүдийн сервер тоног төхөөрөмжүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, техникийн туслалцаа дэмжлэг үзүүлж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. Үүнд:

- Нийслэлийн Мэдээ, мэдээллийн <https://www.ulaanbaatar.mn/> цахим хуудасны англи, монгол хэл дээрх 2.0 хувилбарыг 2022 оны 01 дүгээр сарын 01 сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.
- Нийслэлийн цахим үйлчилгээний <http://eservice.ulaanbaatar.mn/> системээр 2523 үйлчилгээг үзүүлсэн.
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын <https://erp.ulaanbaatar.mn/> системтэй холбоотой 5000 гаруй дуудлагад хариуг өгч ажилласан.
- Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний <https://smartcar.mn/> системээр дамжуулан тээврийн хэрэгслийн татвар 12 тэрбум, зөрчлийн торгууль 559 сая төгрөгийг төлсөн байна. Мөн системтэй холбоотой 1450 дуудлагад хариу өгч ажилласан.
- Худалдан авах ажиллагааны Нээлттэй Улаанбаатар <https://open.ulaanbaatar.mn/>,

- Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сан <https://dms-ulaanbaatar.opendata.arcgis.com/>,
- Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын <http://ldf.ub.gov.mn>,
- Иргэдийн оролцоотой газрын зураглалын <https://manaikhoroo.mn/>,
- Архив албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн <https://edoc.ulaanbaatar.mn>
- “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн <https://service.ulaanbaatar.mn/> систем өдөр тутам иргэдээс ирсэн 10-15 дуудлагыг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэж, 7810 гаруй иргэн аж ахуй нэгж байгууллага тус системээс үйлчилгээ аван үйл ажиллагаа явуулж байна.
- Нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон интернэтийн гэрээтэй 35 байгууллагын гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.
- Нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон нийт 21 байгууллагын 527 хэрэглэгчид хортой кодын эсрэг програм хангамжийг суулгаж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ub.gov.mn домэйн дээр байрлах 193 цахим хуудасны нөөцлөлтийг тухай бүр хийн SSL-ийг сунган хэвийн ажиллагааг ханган ажилласан.
- Smartcar.mn, ulaanbaatar.mn, ublegal.mn, smartub.mn, manaikhoroo.mn веб сайтуудын домэйны гэрээний хугацааг сунгуулан хэвийн ажиллагааг ханган ажилласан.
- Гаднаас хандалттай Ulaanbaatar.mn домэйн бүхий вэб сайтууд, вэб серверүүд дээр шинээр SSL сертификатыг худалдан авч системүүд дээр тохиргоо хийсэн.
- smartcar.mn домэйний сертификатын хугацаа дууссан байсныг шинээр сунгаж SSL-ийн тохиргоо хийсэн.

4.4.Нутгийн захиргааны байгууллагуудад хариуцсан чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, системүүдийн ашиглалттай холбоотой сургалтуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:

- Замын хөгжлийн төв, Тээврийн цагдаагийн газар, Сүхбаатар дүүргийн нийт 20 албан хаагчдад “Орон зайн мэдээллийн систем систем” ашиглалтын сургалт
- “Онлайн бизнес төв” төслийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус системд ажиллах 14 байгууллагын 130 албан хаагчдад 3 удаагийн сургалт уулзалт, 1 удаагийн дүүрэг тус бүрд зориулсан сургалтуудыг тус тус хийсэн.
- УБЗАА-ны Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн албан хаагчдад “Онлайн бизнес төв” системээр согтууруулах ундааны зөвшөөрлийг хэрхэн олгож ажиллах сургалтыг хийсэн.
- Нийслэлийн нутгийн захиргааны 40 албан хаагчдад “Процессын дахин загварчлалын арга зүй” сэдэвт сургалтыг Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулсан.
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сервер тоног төхөөрөмжийн тохиргоонд хяналт тавин зааварчилгаа өгч ажилласан.


Дүүргүүдийн мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дүүргийн серверийн өрөөний аюулгүй байдал болон сүлжээгээр дамжуулан хүргэж буй үйлчилгээнүүдийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

4.5.Нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын мэдээллийн их өгөгдөл үүсгэх, боломжит өгөгдлүүдийг иргэд, олон нийтэд нээлттэй болгох, их өгөгдлийг боловсруулах, дүн шинжилгээ хийх нөхцлийг бүрдүүлэх

“Орон зайн мэдээллийн системд суурилсан Хот байгуулалтын дундын мэдээллийн санг”-ийн 34 дэд сан, 445 давхаргын нээлттэй мэдээллийг <https://dms-ulaanbaatar.opendata.arcgis.com/> цахим хуудаст байршуулж, өгөгдөл мэдээлэл солилцох боломжтой болсон. Орон зайн мэдээллийн системд суурилсан нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санд нийт 4 дэд үүсгэсэн. Үүнд:

- Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Барилгын зөрчлийн мэдээллийн дэд сан
- Нийслэлийн Онцгой Комиссын мэдээллийн дэд сан
- Улсын онцгой комиссын дэд сан
- Нийслэлийн Соёл урлагийн газрын дэд сан


<https://dms-ulaanbaatar.opendata.arcgis.com/> санд цэцэрлэгийн бүртгэл, барилгын зөрчил, хаяг дугаарын зөрчил, COVID19-ийн бүртгэл, цар тахлын хамрах хүрээний бүртгэл, Улаанбаатар хотын хүнсний нөөц, хяналт шалгалтын бүртгэл, Археологийн үл хөдлөх дурсгалын хяналтын бүртгэл зэрэг нийт хийгдсэн бөгөөд тус мэдээллүүдийг бүртгэх боломжтой 8 давхарган хэвийн ажиллагааг хангаж өгөгдөл мэдээллийг шинэчилж байна. Улаанбаатар хотын хяналт шалгалтын бүртгэлийн давхарга



Зураг 1: Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын хяналтын дашборд



Зураг 2: Нийслэлийн төсвийн орлого, татвар, статистикийн хяналтын дашбоард



Зураг 3: Нийслэлийн хөрөнгө оруулалтын хяналтын дашбоард

Power BI технологид суурилсан Нийслэлийн их өгөгдлийг хөгжүүлэх, дата боловсруулалт хийх ажлын хүрээнд дараах өгөгдөл мэдээлэлд Power BI дашборд хөгжүүлж үр дүн дээр анализ төлөвлөлт хийх талаар холбогдох удирдлагуудтай хамтран ажиллаж байна.

- Нийслэлийн сүүлийн 3 жилийн хугацааны 10,074 гаруй өргөдөл гомдлыг боловсруулах дүн шинжилгээ хийх, хянах самбар;
- Нийслэлийн замын 130 уулзвар, 125 зам, 492 хэсэгчилэн ачааллыг тооцоолж түгжрэлийг тооцоолон, их өгөгдлийн дүн шинжилгээг хийж хяналтын самбар хөгжүүлсэн;
- Нийслэлийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын цогц мэдээллийн дүн шинжилгээний самбар;
- Төрийн үйлчилгээний дүн шинжилгээний самбар;
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар тогтмол танилцуулдаг Цагдаа, Онцгой, Мэргэжлийн хяналтын байгууллагуудын тоон мэдээний хяналтын дашбоардыг хөгжүүлсэн;

4.6.Нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын интернэт болон харилцаа холбооны зардлыг хэмнэх шийдлийн санал боловсруулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, нэвтрүүлэх, техникийн хяналт тавих

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.11-д тусгагдсан “Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем төслийг бүрэн хэрэгжүүлнэ” зорилтын хүрээнд замын хөдөлгөөнд оролцож буй бүх талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин үеийн хиймэл оюун ухааны тусламжтайгаар тооцоолол хийх боломжтой “Зам, тээврийн нэгдсэн ухаалаг систем”-ийг 2022-2024 онд бүрэн нэвтрүүлэхээр холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

“Зам, тээврийн нэгдсэн ухаалаг систем” төсөл нь замын хөдөлгөөнд оролцож буй бүх талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин үеийн хиймэл оюун ухааны тусламжтайгаар тооцоолол хийх боломжтой бөгөөд дараах дэд системүүдээс бүрдэнэ.

1. RFID суурилсан замын хөдөлгөөний систем
2. Замын хөдөлгөөн зохион байгуулалтын систем
3. Гэрлэн дохионы удирдлагын систем
4. Авто зогсоолын удирдлагын нэгдсэн систем
5. Нийтийн тээврийн ухаалаг систем
6. Такси болон Тусгай тээврийн удирдлагын систем
7. Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний нэгдсэн “Smartcar” систем сайжруулж жолооч нарыг бүхий л төрлийн мэдээллээр хангах;

Дээрх төслийн хүрээнд технологийн шийдэл болон тооцоо судалгааг холбогдох байгууллагуудын зөвшөөрлүүдийг авч бэлтгэл ажлыг бүрэн хангаж дараахь ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Харилцаа Холбооны зохицуулах хорооноос радио давтамж тодорхойлох RFID уншигч төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ авсан.
- Газрын даргын 2022 оны А/46 дугаар тушаалаар байгуулагдсан “Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийг автоматжуулахад шаардлагатай техник технологи, системийн шийдлээр хангаж ажилласан.
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шинээр нэвтрүүлж байгаа техник, технологийн техникийн даалгавар боловсруулах, техникийн болон сүлжээний саатал, гэмтлийг засварлан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас ашиглалтын хугацаа дууссаны улмаас ашиглах боломжгүй болсон 4 төрлийн 10 тоног төхөөрөмжийн нөхцөл байдлыг тодорхойлж мэргэжлийн дүгнэлт гаргасан.
- НЗД-ын 2022 оны А/912 дугаар захирамжийн хүрээнд Мэдээллийн технологийн шийдлүүдийг ашиглан иргэдийн ажиллаж, амьдрахад таатай ухаалаг хотыг бий болгох хүрээнд 3 бүлэг 12 дэд төсөл бүхий “Дижитал хот” төслийг хэрэгжүүлэхээр техник, эдийн засгийн үндэслэл, технологийн шийдлийг боловсруулан “Дижитал Сити – 2022” арга хэмжээг зохион байгуулж сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.
- Нийслэлийн Эрүүл Мэндийн газраас зохион байгуулсан “UB healthcare week – 2022” арга хэмжээний сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.
- НИТХ-аас зохион байгуулсан “Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний 30 жилийн баярын хурал” арга хэмжээний сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.

НЗДТГ болон ICT групптэй хамтран зохион байгуулсан “2022 – 2024 оны Улаанбаатар хотын цахим шилжилт” арга хэмжээний сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.

4.7.Төрийн болон албаны нууц, хувь хүний нууцтай холбоотой төлбөртэй болон төлбөргүй мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу дамжуулах, байршуулах, хадгалах

Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 1927 албаны и-мэйл хаягийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн болон албаны нууцыг хадгалах, албан хэрэглээний компьютер болон дагалдах тоног төхөөрөмжүүдийг гадна дотны халдлагаас хамгаалах, нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны 35 байгууллагын 1202 албан хаагчдын компьютерийг нийслэлийн нэгдсэн домэйн сүлжээнд холбон хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам болон холбогдох журмын хүрээнд төрийн нууцтай холбоотой ажлын баримт бичгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажилласан.

4.8.Нийслэлийн хэмжээнд нэгдсэн шилэн кабель, гадаад, дотоод сүлжээ зохион байгуулах, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хяналт тавих

Нийслэлийн хэмжээнд нэгдсэн шилэн кабель, гадаад, дотоод сүлжээг зохион байгуулж нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбон ажилласан. Үүнд:

1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг “Нийслэлийн дагуул хот, Эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар” нь шинээр байгуулагдаж Хангарди ордны 2 давхарт шилжин орсонтой холбоотойгоор тус байгууллагын дотоод сүлжээг зохион байгуулж ННС-нд холбосон.
2. “Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” нь Хангарди ордны 11 давхарт шилжин орсонтой холбоотойгоор тус байгууллагын дотоод сүлжээг зохион байгуулж ННС-нд холбосон.

3. “Нийслэлийн Сургалт судалгаа, олон нийттэй харилцах газар” нь агентлаг болон өргөжиж Хангарди ордны 13 давхарт шилжин орсонтой холбоотойгоор тус байгууллагын дотоод сүлжээг зохион байгуулж ННС-нд холбосон.
4. “Эмээлт Эко аж үйлдвэрийн парк” НӨААТҮГ нь Хангарди ордны 3 давхарт шилжин орсонтой холбоотойгоор тус байгууллагын дотоод сүлжээг зохион байгуулж ННС-нд холбосон.
5. “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг дахин боловсруулах газар” нь шинээр байгуулагдан Хангарди ордны 15 давхарт шилжин орсонтой холбоотойгоор тус байгууллагын дотоод сүлжээг зохион байгуулж ННС-нд холбосон.
6. “Бодлого Судалгаа шинжилгээний төв” НТҮГ нь шинээр байгуулагдан Хангарди ордны 13 давхарт шилжин орсонтой холбоотойгоор тус байгууллагын дотоод сүлжээг зохион байгуулж ННС-нд холбосон.
7. Сонгинохайрхан дүүргийн хороодыг бүсээр хувааж дотоод сүлжээний тохиргоог шинэчлэн дүүргийн мэдээлэл, технологийн ажилтанд заавар зөвлөгөө өгөн ажилласан.
8. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны дотоод сүлжээг зохион байгуулж Нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбосон.
9. ЦЕГ-ын Экологийн Цагдаагийн албанаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Гүнт, Өлзийт, Эмээлт, Баруунтурууны шалган нэвтрүүлэх товчоод дээр хяналтын пост байгуулахад шаардлагатай сүлжээний урсгалыг гарган өгч дэмжлэг үзүүлж ажилласан.

4.9. Нийслэлийн хэмжээнд нэгдсэн шилэн кабель, гадаад, дотоод сүлжээний хэвийн ажиллагааг хангах, ашиглалт, үйлчилгээг хариуцах

Нийслэлийн хэмжээнд нэгдсэн шилэн кабель, гадаад, дотоод сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, ашиглалт, үйлчилгээг хариуцан дараах засвар үйлчилгээг цаг тухайд нь шуурхай засварлан ажилласан. Үүнд:

1. Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газрын даргын 2022 оны А/43 дугаар тушаалаар Нийслэлийн нэгдсэн шилэн кабелин сүлжээний гэмтэл, засвар, ашиглалт үйлчилгээ /Сонгинохайрхан дүүрэг/ Баруунтуруун, Эмээлт, 32 дугаар хорооны агаарын шилэн кабелин гэмтлийг оношилж засварласан.
2. Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газрын даргын 2022 оны А/43 дугаар тушаалаар Нийслэлийн нэгдсэн шилэн кабелин сүлжээний гэмтэл, засвар, ашиглалт үйлчилгээ /Хан-Уул дүүрэг/ Морингийн давааны агаарын шилэн кабелин гэмтлийг оношилж засварласан.
3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Гачуурт авто замаас Шархадны аютобусны эцсийн зогсоол хүртэлх 4,27 км авто зам, Улиастайн голын 97,3 м төмөр бетон гүүрийг засварлах ажлын хүрээнд тус зам дагуух гэрэлтүүлгийн шонг буулгаж шилэн кабелиг шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн.
4. Баянгол дүүргийн 14 дэгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэдээлэл Холбооны сүлжээ ТӨХК-ийн 36 дугаар АТС-ын урд байрлах ашиглалтын хугацаа дууссан барилгыг нураах ажлын хүрээнд тус дүүргийн 16, 17, 18 дугаар хороод руу татагдсан агаарын шилэн кабелиг шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн.
5. Кевико ХХК-ийн эзэмшлийн Хужирбулангийн зам дагуух агаарын шилэн кабелин 1 шонг шилжүүлэх, 1 шонг солих ажлын хүрээнд НЦХМТГ-ын эзэмшлийн Гачууртын

шалган бүртгэх товчоо руу татагдсан агаарын шилэн кабелиг шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

6. Кевико ХХК-ийн эзэмшлийн Хан-Уул дүүргийн Морингийн давааны постын агаарын шилэн кабелин шонг шилжүүлэх ажлын хүрээнд НЦХМТГ-ын эзэмшлийн Морингийн давааны шалган бүртгэх товчоо руу татагдсан агаарын шилэн кабелиг шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн.
7. Сонгинохайрхан дүүрэг Баруунтуруун, Эмээлтийн шалган нэвтрүүлэх товчооны агаарын шилэн кабелин гэмтлийг оношилж засварласан.
8. Чингэлтэй дүүрэг Гүнтийн шалган нэвтрүүлэх товчооны агаарын шилэн кабелин гэмтлийг оношилж засварлуулсан.

4.10.Нутгийн захиргааны байгууллагуудын компьютер, техник хангамжийн найдвартай үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ серверийн тоног төхөөрөмж, систем болон дэд бүтцийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Үүнд:

- Интернет үйлчилгээг 33 байгууллагад;
- ННЗ-ны 44 байгууллага, 9 дүүргийн ЗДТГ болон 151 хороонд;
- Цагдаагийн дотоод сүлжээг 113 хороонд;
- Утасгүй интернетийг 155 байршилд;
- ОӨУБЕГ-ийн дотоод сүлжээг 133 хороонд;
- Төрийн сангийн дотоод сүлжээг 6 дүүрэгт;
- Нийслэлийн Газрын албаны дотоод сүлжээг 6 дүүрэгт;
- ННЗБ-ын 238 цахим хуудас
- ulaanbaatar.mn болон ub.gov.mn, citycouncil.mn, ublegal.mn, smartcar.mn зэрэг томоохон системүүдийг;
- ННЗБ-ын мэдээллийн аюулгүй байдал;
- Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сан;
- Нийслэлийн Газрын албаны сервер, тоног төхөөрөмж;
- Нийслэлийн Архивын газрын сервер, тоног төхөөрөмж;
- Нийслэлийн Шуурхай удирдлага зохицуулалтын төвийн сервер, тоног төхөөрөмж;
- ННЗБ-ын физик 46, виртуал 93 сервер;
- ННЗБ-ын 80 систем;

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын сервер, дотоод сүлжээ, тоног төхөөрөмж болон интернет үйлчилгээний доголдол, цахим шуудан шинээр нээлгэх, мөн цахим шуудангийн нууц үг сэргээх, домэйний шинэ хэрэглэгч үүсгэх, нууц үг сэргээх нийт 635 дуудлагуудыг хүлээн авснаас /392 утсаар, 143 албаны цахим хуудсаар, “Дэмжлэг үзүүлэх төвийн үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу тухай бүр шуурхай шийдвэрлэж ажилласан.

4.11.Нийслэлийн нэгдсэн дата төвийн сервер, тоног төхөөрөмжүүдийн мэдээллийн аюулгүй байдал, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, тохиргоо, угсралт суурилуулалтыг хариуцан ажиллах

Нийслэлийн нэгдсэн дата төвийн сервер, тоног төхөөрөмжүүдийн мэдээллийн аюулгүй байдал, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, тохиргоо, угсралт суурилуулалтыг хийн ажилласан. Үүнд:

1. Дата төвд байрлах сүлжээний үндсэн төхөөрөмжүүдэд 2022 оны 3 дугаар сарын 11-нээс 18-ны өдрүүдэд төлөвлөгөөт үзлэг шалгалтыг хийж хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.
2. Радио давтамж тодорхойлох RFID төхөөрөмж болон дата төвийн шинээр худалдан авах сервер систем, FIREWALL тоног төхөөрөмжүүдийн шийдлийг боловсруулж ажилласан.
3. Дундын мэдээллийн сангийн Arcgis системийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх үүднээс database MSSQL сервер долон кор сервис-ийг тусад нь VPS сервер үүсгэж бэлдсэн.
4. Санал дэвшүүлэх системийн серверийг шинээр үүсгэж VPS- үүдийг тохируулсан.
5. TRC VPS сервер ubuntu 18.04 үүсгэж тохируулсан.
6. Марафон VPS сервер ubuntu 20.04 үүсгэж тохируулсан, NodeJS 14, хасура graphql системүүдийг суулгаж тохируулсан.
7. Civilbudget VPS сервер ubuntu 20.04 үүсгэж тохируулсан. Иргэдийн төсөв вебсайтыг байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
8. ERP системийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх ажлын хүрээнд одоо ашиглагдаж байгаа Centos7 системийн main болон security update хийгдэхгүй EOL болж байгаатай холбогдуулан шинээр дараах VPS-үүдийг үүсгэж тохируулсан.
ERP_BACKEND сервер ubuntu 20.04
ERP_FILE сервер ubuntu 20.04
ERP_DB сервер ubuntu 20.04
9. Citycouncilweb VPS Centos 7.9 сервер суулгаж тохируулсан.
10. Хэсгийн ахлагч APP VPS Ubuntu 20.04 сервер суулгаж тохируулсан.
11. Хэсгийн ахлагч DB VPS Oracle Linux 7.9 сервер суулгаж тохируулсан.
12. Товчоодын камерын хяналтын сервер PowerEdge R740xd серверийг суурилуулсан Windows сервер 2019 суулгаж тохируулж бэлдсэн.
13. Linux сервер-үүдийн security болон kernel update-үүдийг хийсэн.
14. Windows OS-той серверүүд дээр 5 болон 6 сарын cumulative update-үүд хийсэн.
15. Интернет сүлжээний traffic-ийг багасгах үүднээс мөн хэрэглэгчийн PC-үүдийн update-үүдийг тогтмол хийж аюулгүй байдлыг хангах зорилгоор Microsoft WSUS(windows update) сервер -ийг DELLR740XD сервер дээр зохион байгуулсан.
16. 16.Blade M620 esxi сервер OS crash болж унтарсан шалтгааныг олж CPU bug kernel patch update хийж хэвийн болгосон.
17. Худалдан авалтын тендер зарлахтай холбогдуулан RFID болон дата төвийн шинээр худалдан авах сервер систем, firewall тоног төхөөрөмжүүд дээр шийдлийг шинэчлэн дахин засварласан.
18. Шинээр Solid waste QR control system server VPS сервер үүсгэж Ubuntu 20.04 үйлдлийн систем суулгаж тохируулсан.
19. Авто үйлчилгээ эрхлэгчдийн систем VPS сервер үүсгэж Centos 7 үйлдлийн систем суулгаж тохируулсан.
20. Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрын VPS сервер үүсгэж Ubuntu 20.04 үйлдлийн систем суулгаж тохируулсан, мөн PostgreSQL баазын систем, React JS- сан ашиглан React JS админ панел, Node JS Javascript runtime системүүд ажиллах орчинг бэлдсэн.
21. Хангарди ордны Хурлын зааланд захиалгын MeetingOrder систем VPS сервер үүсгэж Roscky linux 8 үйлдлийн систем суулгаж тохируулсан.

22. Засаг Даргын Тамгын газарт Lmonitoring сервер VPS үүсгэж Rocky linux 9 суулгаж тохируулсан.
23. Нийтийн тээврийн тусгай зөвшөөрлийн сервер 3 VPS сервер үүсгэж Rocky 8 үйлдлийн систем суулгаж тохируулсан.
24. Товчоодын бүртгэл хяналтын системд зориулан App болон Database 2 VPS сервер үүсгэж Ubuntu 20.04 суулгаж тохируулсан.
25. Дүүрэг хороодын ubiquiti switch-үүдийн тохиргоо болон удирдлагын сервер fujitsu – ийн HDD controller дээр гэмтэл гарч ажиллагаагүй болсныг засаж хэвийн болгосон.
26. Сар бүр Linux серверүүдийн security болон kernel update –үүдийг хийсэн.
27. Сар бүр Windows OS –тэй серверүүд дээр сарын cumulative update –үүд хийсэн.

4.12.Нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудын телехяналтын камеруудын техникийн даалгавар боловсруулах, бүртгэлжүүлэх

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/755 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын телехяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-ын хүрээнд Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдийн нутаг дэвсгэрт камер суурилуулах ажлын нийт 13 техникийн даалгаврыг боловсруулж хүргүүлсэн. Үүнд:

1. “Баянгол дүүргийн 23 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
2. “Баянзүрх дүүргийн хэмжээнд гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх хяналтын телекамерын засвар шинэчлэлт, суурилуулалтын ажил”-ын хүрээнд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрийн камержуулалт ажлын техникийн тодорхойлолт
3. “Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороо, Толгойт дэд төвд хийгдэх цэцэрлэгт хүрээлэнгийн камержуулалт ажил”-ын техникийн тодорхойлолт
4. Сүхбаатар дүүргийн 6, 8, 9 дүгээр хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
5. Хан-Уул дүүргийн 4-10, 12, 12, 14, 16, 21 дүгээр хороодын камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
6. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 5 байршилд тусгай зориулалтын камер суурилуулах ажил”-ын техникийн тодорхойлолт
7. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хогийн цэгүүдийн камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
8. “Хан-Уул дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
9. Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
10. Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
11. Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
12. Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт

13. Сонгинохайрхан дүүргийн 261 дүгээр цэцэрлэгийн камержуулалтын ажлын техникийн тодорхойлолтыг тус тус боловсруулан хүргүүлсэн.
14. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 65 дугаар тогтоолоор “Дүүргийн 4-14, 16, 21 дүгээр хороодын камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн.
15. Баянгол дүүргийн Засаг даргын 2022 оны А/03 дугаар захирамжаар “Дүүргийн 16 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн.
16. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/12 дугаар захирамжийн хүрээнд “Баянзүрх дүүргийн 19, 23 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн.
17. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/506 дугаар захирамжийн хүрээнд “Баянзүрх дүүргийн УС-15 хотхоны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн.
18. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02/313 дугаар тогтоолоор “Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо 92 дугаар цэцэрлэгийн камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлсэн.
19. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02/313 дугаар тогтоолоор “Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо 287 дугаар цэцэрлэгийн камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
20. Улаанбаатар Захирагчийн Ажлын албаны 2022 оны 10 дугаар сарын 21-ний 02/1638 тоот албан бичгийн дагуу “Сүхбаатар дүүргийн 18, 20 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
21. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 05 сарын 30 ны 6/919 тоот албан бичгийн дагуу “Дүүргийн 14, 16, 18 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
22. Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ЭБ-4/03 дугаар тогтоолоор “Дүүргийн 4 дүгээр хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
23. Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ЭБ-4/03 дугаар тогтоолоор “Дүүргийн 8 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
24. Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ЭБ-4/03 дугаар тогтоолоор “Дүүргийн 13 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
25. Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ЭБ-4/03 дугаар тогтоолоор “Дүүргийн 23 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт
26. Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ЭБ-4/03 дугаар тогтоолоор “Дүүргийн 37 дугаар хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолт, тус дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ЭБ-4/03 дугаар тогтоолоор “Дүүргийн 9, 17, 19, 25, 34 дүгээр хорооны камержуулалтын ажил”-ын техникийн тодорхойлолтуудыг боловсруулсан хүргүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/755 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын телехяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-

ын хүрээнд 2022 онд нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг болон нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу камержуулалтын дараахь ажлуудыг хүлээж авах ажлын хэсгүүдийг байгуулан ажилласан. Үүнд:

1. Газрын даргын 2022 оны А/49 дугаар тушаалаар “Камержуулалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах /НД/” ажлыг хүлээн авч дүгнэлтийг гарган ажилласан.
2. Газрын даргын 2022 оны А/67 дугаар тушаалаар “Баянзүрх дүүргийн 8 хороо”, “Хан-Уул дүүргийн 2, 7, 8 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн камержуулалтын ажил”-ын 5% суллах бичиг баримтыг бүрдүүлэн ажилласан.
3. Газрын даргын 2022 оны А/69 дүгээр тушаалаар “Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо 287 дугаар цэцэрлэгийн камержуулалтын ажил”-ыг хүлээн авч дүгнэлтийг гарган ажилласан.
4. Газрын даргын 2022 оны А/77 дугаар тушаалаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгөөр хийгдсэн камержуулалтын ажил”-ыг хүлээн авч дүгнэлтийг гарган ажилласан.
5. Газрын даргын 2022 оны А/82 дугаар тушаалаар “Баянгол дүүргийн 10, 11, 23 дугаар хорооны камержуулалтын ажил”-ыг хүлээн авч дүгнэлтийг гарган ажилласан.
6. Газрын даргын 2022 оны А/93 дугаар тушаалаар “Нийслэлийн авто замын гэрлэн дохиотой уулзваруудад иж бүрэн шон нийлүүлэх, угсарч суурилуулах засвар үйлчилгээ, техник хэрэгсэл гэрээт ажил-ыг хүлээн авч дүгнэлт гарган ажилласан.

4.13.Телехяналтын систем, хяналтын камер, шилэн кабел, гадаад, дотоод сүлжээ, сервер, систем болон тоног төхөөрөмжийн техникийн даалгавар боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, хяналт тавих

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/755 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын телехяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-ын хүрээнд хийгдэж буй камержуулалтын ажлуудын шилэн кабел, телехяналтын камерын зураг төсөлд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Үүнд:

1. “Хан-Уул дүүргийн хороодод суурилагдах камержуулалтын ажил”-ын гадна холбооны зураг төсөл;
2. “Сонгинохайрхан дүүргийн 12, 15, 31, 43 дугаар хороодын нутаг дэвсгэрт хяналтын камер суурилуулах ажил”-ын гадна холбооны зураг төсөл;
3. “Хан-Уул дүүргийн 13, 14 дүгээр хороо Нийтийн эзэмшлийн талбайд телехяналтын камер суурилуулах ажил”-ын гадна холбооны зураг төсөл;
4. “Баянзүрх дүүргийн 4, 21, 27 дугаар хорооны гудамж талбайн камержуулалт ажил”-ын гадна холбооны зураг төсөл;
5. “Чингэлтэй дүүргийн 8, 13 дугаар хорооны гудамж талбайн камержуулалт ажил”-ын гадна холбооны зураг төсөл;
6. “Баянзүрх дүүргийн 5, 8, 21 дүгээр хорооны гудамж талбайн камержуулалт ажил”-ын гадна холбооны зураг төсөл;
7. “Сүхбаатар дүүргийн 9, 10 дугаар хорооны гудамж талбайн камержуулалт ажил”-ын гадна холбооны зураг төсөл;
8. “Хан-Уул дүүргийн 12, 13, 14, 16 дугаар хорооны нутаг дэвсгэр /Биокомбинат-Нисэх, Шувуун фабрик/ чиглэлд камер суурилуулах ажил”-ын гадна холбооны зураг төсөл;

9. Чингэлтэй дүүргийн 8, 13 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 5, 8, 21 дүгээр хороо, Сүхбаатар дүүргийн 9, 10 дугаар хороодын гудамж талбайн дүрс ажиглалтын хяналтын систем суурилуулах шилэн кабелин трассын ажлын зураг төсөл;
10. Баянзүрх дүүргийн 5, 8, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр нийтийн эзэмшлийн талбайд хяналтын камер суурилуулах ажлын зураг төсөл;
11. Чингэлтэй дүүргийн 13, 16 дугаар хорооны нутаг дэвсгэр нийтийн эзэмшлийн талбайд хяналтын камер суурилуулах ажлын зураг төсөл;
12. Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэр нийтийн эзэмшлийн талбайд хяналтын камер суурилуулах, гадна холбооны ажлын зураг төсөл;

4.14. Нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дүрэм, журмуудыг мөрдөж ажиллахад хяналт тавих, эрх бүхий байгууллагатай хамтран зөрчлийг арилгуулах

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Журам батлах тухай” А/477 дугаар захирамжаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий журмыг үндэслэн нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага дотооддоо Мэдээллийн аюулгүй байдлын журам боловсруулан мөрдөн ажиллаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, албан хэрэглээний компьютер болон дагалдах тоног төхөөрөмжүүдийг гадна дотны халдлагаас хамгаалах, нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны 44 байгууллагын сүлжээ, дата төвийн 33 сервер, хадгалах төхөөрөмж, 70 системийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж, 1202 хэрэглэгчийг нэгдсэн домэйн д холбон хэвийн ажиллагааг ханган ажилласан.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдлын хүрээнд Засгийн газрын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/509 дүгээр захирамжийн дагуу нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байгууллагуудын сошиал суваг (Facebook, Twitter, Youtube, Instagram, Steam гэх мэт)-ыг нэгдсэн байдлаар хаах ажлыг зохион байгуулсан. Дата төвд шаардлагатай үзлэг үйлчилгээг мөрдөгдөж буй стандартад нийцүүлэн тухай бүр хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулж хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн төр захиргааны болон харьяа байгууллагуудтай байгуулсан гэрээг шинэчлэх, сунгах ажлуудыг зохион байгуулж, техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна.

4.15. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн чиг үүргийн хүрээний асуудлаар төслийн санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангаж, хяналт тавих

Нийслэлийн харьяа байгууллагуудын үйл ажиллагаандаа ашиглаж буй мэдээллийн системийг дахин төлөвлөсний дагуу орчин үеийн ухаалаг дэвшилтэт систем нэвтрүүлэн “Нэг тархи-Нэгдсэн систем” улаанбаатар хотын цахим шилжилтийн төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэхээр 2022 оны 06 дугаар сарын 08-ний өдөр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон “АЙ СИ ТИ ГРУПП” ХК нь хамтран ажиллах санамж бичиг байгуулсны дагуу “Нэг тархи-Нэгдсэн систем” төслийн хүрээнд 2022-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө болон үйл ажиллагаа бүрийн

дэлгэрэнгүй төлөвлөгөөг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/912 дугаар захирамжаар батлуулсан. 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, нийслэл хотын удирдлага, албан хаагчид, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд танилцуулсан бөгөөд нийслэлийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Үндэсний технологийн тэргүүлэх 70 гаруй компани, 1000 гаруй монгол инженерүүдтэй хамтран боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээ, нийтийн тээвэр зэрэг салбаруудад 12 дэд төслийг дэвшилтэт технологийн шийдлийг нэвтрүүлж иргэдийн цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэх ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэхээр хамтран ажиллаж байгаа бөгөөд төслүүдийн хэрэгжилтийн 90%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Үүнд:

1. Нийслэлийн Нийтийн тээврийн газарт нийлүүлсэн 23 хүүхдийн сургуулийн автобусанд карт уншигч төхөөрөмж болон камер тоног төхөөрөмж суурилуулах
2. Нийслэлийн ерөнхий боловсролын 40 сургуульд “Багш сурагч, эцэг эхийн удирдлагын систем” сурагчийн карт, сургуулийн өөртөө үйлчлэх киоск төхөөрөмж нэвтрүүлэх
3. Нийслэлийн 140 өрхийн эрүүл мэндийн төвд үзлэгийн цаг захиалах киоск машин суурилуулах
4. Хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг цахимжуулах,
5. Дижитал УБ гар утасны аппликейшн нэвтрүүлэх төслүүдийг хэрэглээнд нэвтрүүлээд байна.

4.16. Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Эрх шилжүүлэх А/163 дугаар захирамжийн хүрээнд “Замын хөдөлгөөний зохицуулалт, төлөвлөлтийн нэгдсэн систем”-ийн ажлыг зохион байгуулж захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Захиалагчийн хяналт тавих А/287 дугаар захирамжийн хүрээнд “Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалт /Баянгол дүүрэг”, “Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалт /Баянзүрх дүүрэг”, “Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалт /Хан-Уул дүүрэг”, Теле хяналтын камеруудыг нэгдсэн шилэн кабелийн сүлжээнд холбох /Эмээлт, Баруун туруун, Морин даваа, Өлзийт, Налайх, Гачуурт, Гүнт, Долоон буудал/ ажлыг зохион байгуулж захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Эрх шилжүүлэх А/385 дугаар захирамжийн хүрээнд “Нэгдсэн мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмж”-ийн ажлыг зохион байгуулж захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Эрх шилжүүлэх А/377 дугаар захирамжийн хүрээнд “Энхтайваны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээг зөрчил илрүүлэх камераар тоноглох ажил”-ыг зохион байгуулж захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Эрх шилжүүлэх А/67 дугаар захирамжийн хүрээнд “УС-15 хотхоны камержуулалт /БЗД 8 дугаар хороо/” ажлыг зохион байгуулж захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Эрх шилжүүлэх А/613 дугаар захирамжийн хүрээнд “Камержуулалтын ажил /Хан-Уул дүүрэг/” ажлын захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Эрх шилжүүлэх А/503 дугаар захирамжийн хүрээнд “Технологи их өгөгдөлд суурилсан замын хөдөлгөөнийг цахимжуулах зөвлөх үйлчилгээ” ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Захирамжийн хавсралтыг шинэчлэн батлах А/921 дугаар захирамжийн хүрээнд “Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем”-ийн хүрээнд хэрэгжүүлэх “Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалт (Баянгол дүүрэг) ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах А/1270 дугаар захирамжийн хүрээнд “Авто тээврийн хэрэгслийн цаим гэрчилгээ (RFID tag)-г суурилуулах” ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах А/1313 дугаар захирамжийн хүрээнд “Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем” төслийн хүрээнд хэрэгжүүлэх Тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах А/1369 дугаар захирамжийн хүрээнд “Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвийн серверийн өрөөний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх”, “Автобусны буудлын хяналтын цэг байгуулах (103 буудал)”, “Автобусны буудлын хяналтын цэгийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвтэй холбох сүлжээ, дэд бүтцийн ажил” ажлуудад захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
1	2	3	4	5	6	7
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХИЖҮҮЛЭХ						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаа с албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	10 төрлийн сургалта д хамруулах	12 төрлийн сургалт, форумд 41 албан хаагч хамрагдсан байна.	Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулагддаг төлөвлөгөөт 11 төрлийн сургалтад давхардсан тоогоор 39 албан хаагч хамрагдсан байна. Үүнд: Нийслэлийн түүх, ННЗБ-уудын бүтэц чиг үүрэг-1, Хууль, эрх зүй-3, Төрийн албан хаагчийн манлайлал-4, Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй-14, Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, eDoc системийн хэрэглээ-3, Бизнес процессийн дахин загварчлал-5, Төрийн

					байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион-1, Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх-1, Төслийн удирдлагын үндэс-4, Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь-4 албан хаагч тус тус хамрагдсан байна. Мөн Удирдлагын академи, БНСУ-ын ТЗИнститутын хамтын ажиллагааны хүрээнд МУ-ын ерөнхий сайдын дэмжлэгтэйгээр ТӨРИЙН ОРДОН-д зохион байгуулсан "Урт хугацааны хөгжлийн бодлого цахим шилжилт" сэдэвт олон улсын форумд-2 тус тус хамрагдсан байна.
		Ажлын байран дахь сургалт	-	-	Төлөвлөөгүй
		Мэргэшүүлэх сургалт	2 албан хаагч хамрагдах	4 албан хаагч хамрагдсан байна.	Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад-2, Төрийн албан хаагчийн урт, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад -2 албан хаагч тус тус хамрагдсан байна.
		Туршлага солилцох арга хэмжээ	-	-	Төлөвлөөгүй
		Бусад	Тухай бүр хамруулах	5 сургалтад 13 албан хаагч хамрагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, JCI Монгол хамтран "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд зохион байгуулсан Нийслэл "Rise Academy" сургалтад-5,УБЕГ-аас тоон гарын үсгийн дэд бүтцийг танилцуулах сургалтад-1, НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс Хөдөлмөрийн

						тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нэг мөр ойлгох, сурталчлан таниулах сургалтад -2, Хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлан мэдээл хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад-3, Төрийн албанд ажиллаж байгаа мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилтой “И-Монгол Академи” УТҮГ-аас зохион байгуулж буй цахим сургалтад-2, Төрийн албаны зөвлөлийн 7:14 сургалтад тухай бүр хамрагдах боломжтой албан хаагчид,
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	-	58	Давхардсан тоогоор
			Эмэгтэй албан хаагч	-	17	
			Эрэгтэй албан хаагч	-	13	
			Удирдах албан тушаалтан	-	5	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	25	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	95%	Нийт албан хаагчдын 95% нь Хүний нөөцийн хөгжлийн төв болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	Тухай бүр	1 сургалт	БНСУлсад зохион байгуулагдсан мэдээллийн технологийн салбарын мэргэжилтнийг мэргэшүүлэх 5 хоногийн хөтөлбөртэй сургалтад Технологи, систем хөгжүүлэлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн зохион байгуулагч талын
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	Тухай бүр	1 албан хаагч	
			Эмэгтэй албан хаагч	-	-	

	хамруулсан гадаад сургалт		Эрэгтэй албан хаагч	-	1	зардлаар хамрагдсан болно.
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	1	
		2.3. Гадаад сургалтад хамруулсан байдал, Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	3.3%		
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	Тайлант хугацаанд тус газраас сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зориулан зардал гаргаагүй болно.
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош		Тайлант хугацаан тус газраас Төрийн өөр байгууллагад шилжин ажилласан -2, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн- 2, Хүүхэд асрах чөлөө авсан -2, тус газарт ТАТХуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтаар шилжин ирсэн-2 албан хаагч тус тус шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ

4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	39%	Нийт албан хаагчдад төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн хагас жилээр урамшуулал олгосон бөгөөд шагналд дагалдах мөнгөн урамшуулал олгоогүй болно.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-	4500 төгрөг	Албан хаагчид хоолны зардалд 4000 төгрөгийн, унааны зардалд 500 төгрөгийн нэмэгдэл олгож байна.
5.	Албан хаагчдын албан байрны хэвийн	5.1.	Ажлын байрны таатай орчин сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан	80-аас дээш	85%	Албан хаагчдаас авсан ажлын байрны таатай орчин сэтгэл ханамжийн санал асуулгаар нийт албан хаагчдын 85% нь

	нөхцөлийг бүрдүүлэх		хаагчдын сэтгэл ханамж)			ажиллах орчин, нөхцөл таатай байна гэж хариулсан байна.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд)	1-ээс дээш	100%	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвд 2022.12.15, 16-ны өдрүүдэд хамруулахаар төлөвлөн хуваарь гарган ажиллаж байна.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100%	Нийт 27 албан хаагч хамруулна.
7.	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Тухай бүр	100%	Тус газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 2 албан хаагчид тус бүр 300.000 төгрөгийн мөнгөн тусламж, гэр бүлийн гишүүн нь хүнд өвдсөн 1 албан хаагчид 300.000 төгрөгийн 1 удаагийн буцалтгүй тусламж, ар гэрт нь гарсан буяны ажилд 3 албан хаагчид 400.000 төгрөгний буцалтгүй тусламж тус тус олгосон байна.

Засгийн газрын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжийг үндэслэн 15 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 5 дугаар 25-ны өдрийн 27 дугаар хурлаар хэлэлцүүлж хянуулан Төрийн албаны зөвлөлөөс батлуулах зөвшөөрлийг авсан.

Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу нийслэлийн Засаг даргын 2022 оны А/646 дугаар захирамжийг үндэслэн 4 албан хаагчид зэрэг дэв олгох ажлыг зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 192, 194 тоот тогтоолуудыг үндэслэн газрын даргын 2022 оны А/53 дугаар тушаалаар нийт албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу шинээр томилогдсон төрийн үйлчилгээний 2 ажилтантай Хөдөлмөрийн гэрээ, төрийн захиргааны 1 албан хаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 10 албан хаагчийн ажлыг ажил хүлээлцэх хуудсаар хүлээлцэн холбогдох баримтыг бүрдүүлж ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу төрийн албанд шинээр томилогдсон 4 албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг хянан хуулиар хамгаалагдсан нууцлалыг хариуцан ажиллаж байна.

Байгууллагын хэмжээнд төрийн жинхэнэ 17 албан хаагч харьяа хэлтэс нэгжийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэж, албан тушаалын тодорхоллын дагуу 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 оны хагас, бүтэн жилийн байдлаар тайлагнаж ажилласан. Байгууллагын албан хаагчдын 2022 оны хагас, бүтэн жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх Үнэлгээний багийг газрын даргын тушаалаар байгуулж, албан хаагчдыг үнэлж дүгнэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулсан.

Газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг боловсруулж батлуусан Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 2 албан хаагчид тус бүр 300.000 төгрөгийн мөнгөн тусламж, гэр бүлийн гишүүн нь хүнд өвдсөн 1 албан хаагчид 300.000 төгрөгийн 1 удаагийн буцалтгүй тусламж, ар гэрт нь гарсан буюны ажилд 3 албан хаагчид 400.000 төгрөгний буцалтгүй тусламж тус тус олгосон байна.

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын 54 хүүхдэд гарын бэлэг гардуулах ажлыг зохион байгуулсан.

Байгууллагын албан хаагчдыг сургах мэргэшүүлэх 2022 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалт судалгааны төвөөс зохион байгуулагддаг төлөвлөгөөт 11 төрлийн сургалтад давхардсан тоогоор 58 албан хаагчдыг тухай бүр нь хамруулж ажилласан. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, JCI Монгол хамтран “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд зохион байгуулсан Нийслэл “Rise Academy” сургалтад 1 албан тушаалтан хамрагдсан.
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан Цахим гарын үсгийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд тоон гарын үсгийн дэд бүтцийг танилцуулах сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
- Шинэчлэн батлагдсан архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийг таниулан сурталчлах сургалтад 1 албан хаагч, байгууллагын хэлтэс, албадын удирдлагуудад зориулсан сургалтад 4 хэлтэс нэгжийн дарга нар тус тус хамрагдсан.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нэг мөр ойлгох, сурталчлан таниулах зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын хууль, эрх зүй, хүний нөөцийн ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтад 2 албан хаагч хамрагдсан.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, Удирдлагын академитай хамтран төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулсан 2022 оны 40 цагийн багц сургалтад 1 албан хаагч хамрагдсан.
- Төрийн албанд ажиллаж байгаа мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “И-Монгол Академи” УТҮГ-аас зохион байгуулж буй цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж байна.
- Нийслэлийн түүх, ННЗБ-уудын бүтэц чиг үүрэг-1, Хууль, эрх зүй-3, Төрийн албан хаагчийн манлайлал-4, Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй- 14, Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, eDoc системийн хэрэглээ-3, Бизнес процессийн дахин загварчлал-5, Төрийн

байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион-1, Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх-1, Төслийн удирдлагын үндэс-4, Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь-4 албан хаагч тус тус хамрагдсан байна.

- Удирдлагын академи, БНСУ-ын ТЗИнститутын хамтын ажиллагааны хүрээнд МУ-ын ерөнхий сайдын дэмжлэгтэйгээр ТӨРИЙН ОРДОН-д зохион байгуулсан "Урт хугацааны хөгжлийн бодлого цахим шилжилт" сэдэвт олон улсын форумд-2 тус тус хамрагдсан байна.
- Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад-2, Төрийн албан хаагчийн урт, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад -2 албан хаагч тус тус хамрагдсан байна.

Авлигын эсрэг хуулий үйлчлэлд хамаарах 7 албан тушаалтан 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтыг “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалын жагсаалт”-ыг хүснэгтийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан тоотоор хүргүүлсэн бөгөөд хуулийн хугацаанд нь хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлгийг авч баталгаажуулж ажилласан. 2021 оны ХАСХОМ-ыг 7 мэдүүлэг гаргагчаас хугацаанд нь мэдүүлж, хянан, бүртгэн, баталгаажуулж, ХАСХОМ-1 тайлан, ХАСХОМ-2 тайланг тус тус НЗДТГ-т хүргүүлж ажилласан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу шинээр албан тушаалд томилогдсон, дэвшин ажилласан 4 албан хаагчийн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх мөн Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулсантай холбоотой 8 албан хаагчийн Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ Авлигатай тэмцэх газрын цахим системд хугацаанд нь мэдүүлэх ажлыг зохион байгуулсан.

3.3 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн үнэлгээтэй холбоотой мэдээлэл.

Байгууллагын одоогийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд бизнес процессын шинжилгээ хийлгэж байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний цар хүрээ болон олон улсын ижил төстэй байгууллагуудын сайн туршлага дээр үндэслэн бүтэц, орон тоог загварчилаж, үр бүтээмжийг нэмэгдүүлж, зохион байгуулалтыг шинэчилж гаргасан.

Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байдал, эдийн засгийн үр ашиг нэмэгдсэн эсэхээр илэрхийлнэ.

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн портал [Eservice](#), төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал [E-mongolia](#) зэрэг томоохон шилжилтүүдийн бий болгосон. E Mongolia-р гэхэд өнөөдрийн байдлаар 55 байгууллагын 606 үйлчилгээнээс давхардсан тоогоор 8.070.000 гаруй үйлчилгээг авч өөрсдийн ажил амьдралдаа ашиглаж байна.

Нийслэлийн бүх шатны **1,230** байгууллагын **28,376** албан хаагчдыг нэг платформ дээр нэгдсэн удирдлагаар хангах, хяналтын тогтолцоог боловсронгуй болгосон UB ERP систем байна. Жишээ нь төрийн анхан шатны харилцаа болох албан тоотыг тоон гарын үсгээр баталгаажуулан 100% цахимаар хоорондоо солилцдог болсноор **1,940,066** албан бичгийг цахимаар солилцож **2,565,275** цаасыг хэмнэсэн. 1 албан тоотыг илгээхэд 1-3 хоногийн хугацаа, цаас, шуудангийн зардлууд ордог байсан бол одоо тухайн бодит цаг хугацаанд хоорондоо солилцох боломжтой болсон. “Төрийн үйлчилгээний цахим шилжилт” төслийн хүрээнд 75 гаруй тэрбум төгрөг хэмнэсэн байна.

Мөн Нийслэлийн нэгдсэн төвүүд дэх авто тээврийн хэрэгслийн албан татварын үйлчилгээний цэгүүдийн ачааллыг багасгаж, иргэдийн цаг завьг хэмнэн, тээврийн хэрэгслийн татвар төлөлтийг эрчимжүүлэх хүрээнд Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем болон “Smartcar” аппликейшнийг 2017 онд нэвтрүүлсэн бөгөөд тус системийг ашиглан авто тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, зам ашигласны төлбөрийг бүх банкны онлайн гүйлгээний эрхтэй төлбөрийн карт, QPay үйлчилгээ ашиглан **234,615** иргэн онлайнаар төлбөрөө төлж **18,825,154,973** төгрөг, замын хөдөлгөөний зөрчлийн торгуулийг **396,530** иргэн **8,131,608,427** төгрөгийн төлбөр төлж улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нийслэлийн нэгдсэн сүлжээний дэд бүтцийн хангамж нэмэгдсэн эсэхээр дүгнэнэ.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Улаанбаатар хотын шалган нэвтрүүлэх 7 товчоод зэргийг хамарсан 360 гаруй км шилэн кабелийн арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээ болон Багануур, Багахангай, Налайх, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар болон 151 хороодод суурилуулсан утасгүй интернетийн бүсийн хэвийн ажиллагаа аюулгүй байдлыг тус тус ханган ажилласан.

Нийслэлийн Дата төвийн сүлжээ, сервер, тоног төхөөрөмжийн ажиллах нийт хугацааг хэвийн бус ажилласан хугацаанд харьцуулсан харьцаагаар дүгнэнэ.

Нийслэлийн Дата төвд зориулалт бүхий 12 rack, 93 сервер, хадгалах төхөөрөмж, 80 систем, 269 цахим хуудасны мэдээлэл байрладаг бөгөөд тэдгээрийн хэвийн найдвартай 24/7 горимоор тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. Нийслэлийн дата төв эрчим хүч тасалдсан үед 3 цаг ба түүнээс дээш хугацаанд хэвийн найдвартай ажиллах бололцоотой болсон.

Мэдээллийн аюулгүй байдлын түвшин: Төрийн захиргааны бүх төрлийн баримт бичиг, мэдээ мэдээлэл устгагдах, зүй бусаар нийтэд тараагдах, халдлагад өртөх эрсдэлийн түвшингийн хувиар илэрхийлнэ.

Нийслэлийн нэгдсэн сүлжээнд ойролцоогоор 60,000,000 орчим халдлага хийх оролдлого хамгаалалтын төхөөрөмжид буюу галт хананд бүртгэгдсэн байна. Эдгээр халдлагаас хамгаалах нэгдсэн сүлжээний орчинд ажиллаж буй байгууллага, албан хаагчдад ямар нэг эрсдэл учраагүй байна.

3.4 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг үндэслэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, уулзалтыг журмын дагуу бүртгэлжүүлэн тухай бүр шийдвэрлэж тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд байгууллагын хэмжээнд нийт 22 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс 2 талархалыг хүлээн авч байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй 1 өргөдлийг буцааж, 19 өргөдөл гомдлыг бүртгэж холбогдох албан тушаалтанд шилжүүлж цаг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Нийт өргөдлийн 93,9 хувийг ажлын 4 өдөрт шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4.5 хоног байна.

3.5 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл



Байгууллагын хэмжээнд 2022 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 8 төсөл арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ 100%, 4 төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосон.

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэл
1	“Иргэн аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал” e-mongolia системд холбох	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж худалдан авах ажиллагааг зарласан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосонтой
2	“Call center дуудлагын төвийг өргөжүүлж, дахин загварчлан сайжруулах ажил”	
3	“Нийслэлийн Хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн баяжуулалт”	
4	“Нийслэлийн татвар, төлбөр, хураамжийн нэгдсэн тогтолцоо” дэд төсөл хэрэгжүүлэх	
5	Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем	100%
6	“Онлайн бизнес төв” дэд төсөл хэрэгжүүлэх	100%
7	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP системийн нэмэлт хөгжүүлэлт	100%
8	Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем	100%

Байгууллагын хэмжээнд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/163 дугаар захирамжаар эрх шилжсэн бөгөөд “Авто замын түгжрэлийг бууруулах зарим төсөл арга хэмжээ”-ний жагсаалтад тусгагдсан “Замын хөдөлгөөний зохицуулалт, төлөвлөлтийн нэгдсэн систем” төслийн хүрээнд хийгдэх ажлуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4-т заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулагдсан бөгөөд гэрээнд тусгагдсан ажлууд төлөвлөгөөний дагуу 100% хийгдэж хүлээн авч ажилласан. Үүнд:

Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем


Улаанбаатар хотын авто замын гэрлэн дохионы удирдлагын систем, авто замын гэрлэн дохиотой уулзваруудыг радио давтамж тодорхойлох /RFID/ уншигч төхөөрөмжөөр бүрэн тоноглох, Энхтайвны өргөн чөлөөний 1 дүгээр эгнээ болон БГД -ийн авто замын 2 уулзварыг иж бүрэн камержуулах, нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоодын төлбөр хураах цэгийг цахимжуулж төлбөрийн нэгдсэн системд холбох, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн үйл ажиллагааг сайжруулах, замын хөдөлгөөний төлөвлөлт зохицуулалтын нэгдсэн системийг цогц байдлаар хэрэгжүүлэхээр дэд бүтцийн ажлыг зохион байгуулж ажилласан.



Oct 31, 2022 01:48:24
СБД. Дөлгөөн нуур

1. Нийслэлийн төвийн 6 дүүргийн гэрлэн дохиотой 161 уулзвараас 138 уулзвар, оношлогооны 5 төв, П хэлбэрийн 11 байршил (Гүнтийн пост, Сансар клонк, Шангри-ла төв, Натурын 32А байр, Өгөөж үйлдвэр, Гэсэр сүм уулзвар Нарантуул баруун, Нарны гүүр зүүн, Дөлгөөн нуур урд, Өлзий төв урд)-д Г хэлбэрийн 343 шон болон П хэлбэрийн шонгуудад тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг унших зориулалт бүхий 455 ширхэг RFID уншигч төхөөрөмж, 1036 антена суурилуулснаар Улаанбаатар хотын 161 уулзвараар нэвтрэн өнгөрөх тээврийн хэрэгслийн торгууль, даатгал, татвар, оношилгоо шалгах болон хар жагсаалтад бүртгэлтэй тээврийн хэрэгслийг илрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.

2. Энхтайваны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээ буюу Таван шарын уулзвараас Офицерын уулзвар хүртлэх нийт 44 байршилд 45 ширхэг тээврийн хэрэгслийн дугаар илрүүлэгч болон зөрчил илрүүлэгч камер суурилуулж Замын хөдөлгөөний удирдлагын төвийн торгуулийн системтэй интеграци хийсэн. 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Энхтайваны өргөн чөлөөний 1-р эгнээгээр зорчсон 3,156,560 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна.



3. Нийслэлийн харьяа нийт 8 шалган бүртгэх товчоод /Баруун түрүүн, Налайх /Хоолт/ налайх тэрэлж, түргэний гол, эмээлт, Гүнт, Гачуурт, Морингийн даваа/-д дугаар таних, чиглэлийн, өрөөний дотрох, орчны хяналтын эргэдэг нийт 57 камер болон бусад тоног төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулсан.



Нийслэлийн ойр орчмын шалган нэвтрүүлэх 4 товчоод /Баруун түрүүн, Налайх Тэрэлж, Түргэний гол, Эмээлт/-ын төлбөр авах цэгт цахим төлбөрийн системийг 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр нэвтрүүлсэн бөгөөд төлбөрийн цахим систем нь шалган бүртгэх товчоогоор нэвтэрч буй тээврийн хэрэгслийн эзэмшигч иргэнд дараах байдлаар нэхэмжлэхийг илгээж төлбөрийг хураана. Үүнд:



- Хаан, Голомт /Сошэйл пэй/, Худалдаа хөгжлийн банкнуудын төлбөрийн үйлчилгээний аппликейшнд “хот хоорондын авто зам ашигласны хураамж” цэс байрших бөгөөд иргэн тээврийн хэрэгслийн улсын дугаараа бүртгүүлсэн тохиолдолд төлбөр автоматаар хасагдаж төлөгдөнө;
- Мобикомын “Монрау” төлбөрийн үйлчилгээний аппликейшнд “замын хураамж” цэс үүссэн бөгөөд иргэн тээврийн хэрэгслээ бүртгүүлснээр монпэй цахим хэтэвчээс болон бүртгүүлсэн арилжааны банкны картаас нь автоматаар хасагдаж төлөгдөнө;
- Тээврийн хэрэгслийн үйлчилгээний нэгдсэн <https://smartcar.mn/> системд:

- Иргэн арилжааны бүх банкны төгрөгийн картаа холбосноор товчооны төлбөр автоматаар хасагдаж төлөгдөнө;

- Холбосон картын үлдэгдэл хүрэлцэхгүй эсвэл картаа холбоогүй тохиолдолд нэхэмжлэх хэлбэрээр үлдэж дараа төлөлтөөр Qрау-ээр төлөх боломжтой болсон.

Нийслэлээс гарах, орох товчоодын ачаалал багасаж, биет байдлаар төлбөр авах ажиллагааг халж тээврийн хэрэгслийн татвар, даатгал, оношилгоонд хамрагдсан байдал зэрэгт хяналт тавих, цаашлаад зөрчилтэй тээврийн хэрэгслийг илрүүлэх аппликейшнийг бий болгож, цахим төлбөрийн системд олон төрөлт цахим төлбөрийн арга хэрэгслийг нэвтрүүлж, хүний оролцоог багасгах давуу талууд бий болох юм.

4. Нийслэлийн Дата төвийн мэдээллийн аюулгүй байдал, сервер сүлжээний тоног төхөөрөмжийг өргөтгөх хүрээнд нийслэлийн авто замын 161 байршилд суурилуулах RFID уншигч төхөөрөмжийн систем, шалган бүртгэх 7 товчоодын төлбөр хураалтын болон камерын систем, авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүдийг хэвийн ажиллуулахад шаардагдах сүлжээ болон серверийн тоног төхөөрөмжүүд суурилуулж бүрэн ажиллагаанд оруулсан.



5.Нэгдсэн мэдээллийн систем /Цагдаагийн систем/, програм хангамж, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд Тээврийн цагдаагийн албанд дараахь тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Үүнд:

- 1.Албан хаагч нар ашиглах бэлэн бус торгуулийн төхөөрөмж
- 2.Албан хаагч ашиглах радио холбооны гар станц иж бүрдэл
- 3.Мэдээллийн системийн хамгаалалтын төхөөрөмж Firewall
- 4.Live steaming Group PTT iin VMS
- 5.Car camer streaming program
- 6.Nas Server
- 7.Nas Server-ийн хатуу диск
- 8.GPU server
- 9.RTSP server
- 10.Камерын дүрс, мэдээллийн боловсруулах хяналтын дэлгэц.
- 11.Албан хаагч нарын энгэрийн камер бүрэн нийлүүлэгдсэн.

6."Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний нэгдсэн Smartcar.mn 3.0 шинэ хувилбарт тээврийн хэрэгслийн албан журмын даатгал, оношилгооны мэдээлэх үйлчилгээ, замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийн мэдээлэх үйлчилгээ, засвартай болон түр хаасан замыг мэдээлэх үйлчилгээ, татвар, торгууль, хот хоорондын зам ашигласны хураамж төлөх үйлчилгээ, төлбөртэй зогсоолын мэдээлэл харах, замын хөдөлгөөний дүрмийн мэдээллийн санг үүсгэсэн. Мөн тээврийн хэрэгслийн хяналтын цахим гэрчилгээ /RFID tag/-ний бүртгэлийн backoffice-ийн модулийг тус тус хөгжүүлсэн.

Нийтийн тээврийн газрын ачаа тээвэрлэх ЕС зөвшөөрөл олгох үйлчилгээ, нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттай оролцуулах түр зөвшөөрөл олгох үйлчилгээг цахимжуулах дэд бүтцийг бий болгосон.

7.Газрын зургийн суурь системийг ашиглан дараахь мэдээлийг иргэн мэдээлэл авах болон төрийн байгууллагууд анализ дүгнэлт хийх боломжтой юм.

- Нийтийн тээврийн автобус болон хүүхдийн автобусны зорчилтын байршлын GPS-ын мэдээлэл, мөн чиглэлийн мэдээлэл, дамжин суух буюу дамжилтын мэдээлэл.
- Засвартай зам болон түр хаасан замын мэдээлэл.
- Гэрлэн дохионы байршил болон удирдлагын системийн холболтыг хийх.
- Нийслэлийн товчоодын нэвтрэлтийн болон бодит цаг хугацааны ачааллын мэдээлэл.
- RFID уншигчийн байршил болон атрибутын мэдээлэл харуулах.
- 2-3 эгнээ замын агшны хурдны зөрчил болон бусад зөрчлийн мэдээлэл.
- Зогсоолын байршил болон бодит цагийн ашиглалтын мэдээлэл.
- Оргил ачаалалтай нэвтрэлтийн болон бодит цаг хугацааны ачааллын мэдээллийг video stream-р харах.

8.Улаанбаатар хотын “Замын хөдөлгөөний зохицуулалт, төлөвлөлтийн нэгдсэн систем”-ийг хууль эрх зүйн орчинд нийцүүлэн зөв, оновчтой төлөвлөхийн тулд системийн энтерпрайз архитектур буюу мэдээлэл солилцох нэгдсэн тогтолцоог боловсруулах, Улаанбаатар хотын авто замуудаар зорчиж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, замын ачаалал, тээврийн хэрэгслийн зөрчлийн мэдээллийг хянах, төлбөртэй зогсоол болон авто

замын төлбөр хураалт, түүний хяналтын үйл ажиллагааг автоматжуулах дэд системүүдийн нэгдсэн төлөвлөлт, архитектур зураглал гаргах, мэдээлэл солилцох стандарт болон Зорчих хөдөлгөөний нэгдсэн системийн үйл ажиллагааны журмын төслүүд боловсруулагдсан, процессын шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээг хийсэн.

Улаанбаатар хотын зам, тээврийн асуудал хариуцсан төрийн байгууллага /Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Албан журмын даатгагчдын холбоо/-ууд болон замын хөдөлгөөнд оролцогч талуудын харилцан уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох чадварыг технологийн тусламжтайгаар сайжруулж мэргэжлийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологийн шийдлийг нэвтрүүлэхэд шаардлагатай техник хангамж болон програм хангамжийн нэгдсэн дэд бүтцийн тогтолцоог бий болгож замын хөдөлгөөнийг хянах, удирдах, дүн шинжилгээ, төлөвлөлт хийх “Зам, тээврийн нэгдсэн систем”-ийн тогтолцооны суурийг тавьсан.

“Онлайн бизнес төв” дэд төсөл хэрэгжүүлэх

Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимжуулахаар “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд хэрэглэнд нэвтрүүлсэн бөгөөд дүүргүүдийн худалдаа үйлчилгээний хэлтсээс иргэн, аж ахуйн нэгжид олгодог үйл ажиллагаа эрхлэх 83

нэр төрлийн зөвшөөрлийн шинжтэй эрх олгодог үйлчилгээнүүдийн бүрдэл бичиг баримт, шат дамжлагыг багасган цахимжуулж 5 минутын дотор үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 275186 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 7810 хүсэлтийг ирүүлснээс 6061 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. Мөн Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанаас олгодог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 29 тусгай зөвшөөрлийг цахимжуулсан.


Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP системийн нэмэлт хөгжүүлэлт

Нийслэлийн бүх шатны 1,322 байгууллагын 30 мянга гаруй албан хаагчид, байгууллага хоорондоо орон зай, цаг хугацаанаас үл хамааран харилцаж албан бичиг шуурхай солилцох нэгдсэн платформтой болж цаасан суурьт ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр 1 албан тоотыг илгээхэд шаардагддаг байсан хугацаа, цаас, шуудангийн зардлуудыг халж түргэн шуурхай хоорондоо солилцдог болж төрийн хэмнэлтийг бий болгож 2,565,275 цаасыг хэмнэсэн томоохон систем юм. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын "UB ERP" системд 2022 онд дараахь нэмэлт модулиудыг хэрэглээнд нэвтрүүлж байна. Үүнд:

- Хангарьд ордны 14 давхарын хурлын заал захиалгын модуль
- Нийслэлийн Төр захиргааны авто баазын автомашин захиалгын модуль
- Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн дэд модуль
- Гэрээ бүртгэлийн модуль

Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем

Баянгол дүүргийн Модны хоёрын уулзвар болон Төмөр замын сургуулийн урд уулзварууд дээр 3 цэгт дугаар илрүүлэгч, хурд хэмжигч, улаан гэрлийн зөрчил, эгнээ байрны зөрчил, давхар эргэлтийн зөрчил илрүүлэх камеруудаар бүрэн тоноглохоор шонгийн угсралт, суурилуулалтын ажлын хүрээнд Модны хоёрын уулзварт нийт 17 камер бүрэн суурилуулж ажиллагаанд оруулсан бөгөөд Төмөр замын сургуулийн уулзварын дэд бүтэц кабел, шонгийн суурилуулалтын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж дууссан.



3.6 “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д тухайн жилд гаргах тайлан мэдээний тухай мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 374 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 1106 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу дараах тайлангуудыг Захирамжлалын баримт бичгийн гүйцэтгэлийн www.Lmonitoring.ub.gov.mn цахим систем болон албан тоотоор цаг хугацаанд нь НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст тайлагнаж ажилласан. Үүнд:

- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2022 оны нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой 2 зорилтын 12 арга хэмжээний хэрэгжилтийг 2022 оны хагас, бүтэн жилийн байдлаар тайлагнаж ажилласан бөгөөд хэрэгжилт 87,3% байна.
- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэх нийт 5 зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж ажилласан бөгөөд хэрэгжилт 91% хувьтай байсан.
- Байгууллагын хэмжээнд хяналтанд бүртгэлтэй 18 тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн удааширсан ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж 2022 оны хагас, бүтэн жилийн байдлаар МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг 1, Засгийн газрын 1 тогтоол, хуралдааны тэмдэглэл 1-ийн хэрэгжилтийг боловсруулан НЗДТГ-т тайлагнасан бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байсан.
- Нийслэлийн Удирдах ажилтнуудын 2022 оны шуурхай хуралдааны батлагдсан хуваарийн дагуу 2022 оны нийт 27 удаагийн хурал зохион байгуулагдсанаас байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой болон нийт байгууллагуудтай холбоотой 131 үүрэг даалгаврын биелэлтийг www.ulaanbaatar.mn, erp.ulaanbaatar.mn цахим системд тухай бүрд нь байршуулж ажилласан.
- Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг хагас, бүтэн жилийн байдлаар НЗДТГ-т хүргүүлж ажилласан.
- Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлтийг НЗДТГ-т хүргүүлсэн.
- Нийслэлийн Зорилтот жилийн тайланг 2022 оны хагас, бүтэн жилээр нэгтгэн хүргүүлж ажилласан.
- Зам, тээврийн хөгжлийн сайд Нийслэлийн Засаг даргатай байгуулсан “Санамж бичиг”-ийн 1, 2, 3, 4-р улирлын байдлаар нэгтгэн НЗДТГ-т тухай бүр нь тайлагнасан бөгөөд Газрын даргын зөвлөлийн хурлаар танилцуулсан бөгөөд дээрх бодлогын баримт бичгүүдийн биелэлт, фото, график тайлан, зөвлөмжийн тайлан, хяналт шинжилгээ үнэлгээний ажлын танилцуулга, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийг тус тус бэлтгэн НЗДТГ-т албан тоотоор цаг хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулсан

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ:

4.1 Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

Үйл ажиллагааны ил тод байдал

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллагын <https://it.ulaanbaatar.mn/> цахим хуудсын агуулга, загвар дизайн, бүтэц зохион байгуулалт, програмчлал, аюулгүй байдал, нууцлал хамгаалалтыг шинэчлэн сайжруулсан. Байгууллагын дэвшүүлсэн зорилт, эрхэм зорилго, байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажил, газрын бүтэц зохион байгуулалтыг <https://it.ulaanbaatar.mn/> цахим хуудсанд нээлттэй байршуулж ажилласан.

Албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны захирамжийн хүрээнд иргэд аж ахуй нэгжтэй уулзах хуваарь болон иргэдийн өргөдөл гомдол, албан бичиг хүлээн авах ажилтны нэр, холбоо барих хаягийг дэлгэрэнгүй байршуулсан.

Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөртэй холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийг бэлтгэн хариуцсан мэргэжилтэнд өгч байгууллагын цахим хуудсаар иргэд олон нийтэд нээлттэй таниулан сурталчлах ажлуудыг зохион байгуулсан.

Хүний нөөцийн ил тод байдал

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/100 дугаар захирамжаар батлагдсан дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжийг биелүүлэх үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, дагаж мөрдөх, ёс зүйн зөрчилтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор газрын “Ёс зүйн дүрэм”-ийг <https://it.ulaanbaatar.mn/> цахим хуудсанд нийтэлж ил тод байдлыг хангаж ажилласан.

Байгууллагын зорилт, чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, гүйцэтгэлд суурилсан бүтээлч байдал, тогтвор суурьшилтай чадварлаг боловсон хүчнийг бэхжүүлэх албан хаагчдын авьяас, чадварыг хөгжүүлэх зорилгоор 2021-2024 онд авч хэрэгжүүлэх “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” болон албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах чиглэлээр 2021-2024 оны Сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2022 оны сургалтын төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн, хүний нөөцийг чадавхижуулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээллийг <https://it.ulaanbaatar.mn/> цахим хуудаст тухай бүр байршуулж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

Тендерийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, авлигаас урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд 2022 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалтыг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/224 дугаар захирамжаар батлагдсан бөгөөд эдгээр хөрөнгө оруулалтын ажлуудын техникийн даалгаврыг боловсруулан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Дээрх ажлуудын тендерийг нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар <https://www.tender.gov.mn/> цахим хуудсуудад тухай бүрт нь байршуулж ажилласан.

Төсөв, санхүүгийн ил тод байдлын чиглэлээр

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр 16 нэр

төрлийн мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал, хагас жил, бүтэн жилээр гарган, цаг хугацаанд нь нээлттэй мэдээлж ажиллаж байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой санхүүгийн тайлан, цалингийн зардал, хандив тусламж төсөвт байгууллагын батлагдсан төсөв, зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагаанаас олсон орлого, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт зэрэг 9 төрлийн мэдээлэл хөрөнгө оруулалт тендертэй холбоотой хөрөнгийн зардал, тендерийн ерөнхий мэдээлэл, 5 саяас дээш худалдан авалтын мэдээлэл
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой хийгдэж байгаа шууд худалдан авалт, нээлттэй тендерийн мэдээлэл, байгууллагын урсгал зардлаар гэрээ байгуулагдан хийгдсэн ажлуудыг Шилэн дансны тухай хуулийн дагуу сар бүрийн 8-ны дотор хагас жилийн байдлаар 13 төсөл, арга хэмжээг цаг алдаггүй оруулж ажилласан.

Байгууллагын бүтэц орон тооны 3 удаагийн өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал үүсээгүй болох зэрэг мэдээ мэдээллийг сар бүрийн 08-ны дотор шилэн дансанд оруулан хавсаргах материалыг PDF файлаар хөрвүүлэн нээлттэй мэдээллэсэн.

ТАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ:

5.1 Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд дараахь байгууллагуудтай хамтран ажилласан. Тухайлбал:

- Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай хамтран Үндэсний их баяр наадмын үеэр Төв цэнгэлдэх хүрээлэн болон Хүй долоон худагт худалдаа, үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг Онлайн бизнес төвийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ээр бүртгэх, хүсэлтийг шийдвэрлэх ажлыг хамтран зохион байгуулсан.
- Татвар, төлбөр хураамжийн нэгдсэн систем хөгжүүлэх ажлын даалгавар дээр Нийслэлийн Татварын газраас мэргэжил аргазүйн туслалцаа авч хамтран ажилласан.
- Нийслэлийн сургалт судалгаа олон нийттэй харилцах газартай хамтран “Иргэний санал дэвшүүлэх цахим систем”ийг нэвтрүүлсэн. Тус систем санал дэвшүүлэх, санал өгөх, судалгаа, санал асуулга гэсэн нэмэлт модулиудтай ба санал асуулга, судалгааны модуль бүрэн хэрэглээнд нэвтрээд байна.
- Азийн сангийн Хотын засаглалыг сайжруулах төсөлтэй хамтран Нийслэлд худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг ил тод, хялбар хүргэх, хууль тогтоомж, стандарт, шаардлагын талаарх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, тэдний санал, хүсэлтийг өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх “Онлайн бизнес төвийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системийг нэвтрүүлсэн.

- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай хамтран нийслэлийн хэмжээнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын мэдээллийн санг нэгтгэж, өгөгдлүүдийг боловсруулан, бодит цаг хугацааны хяналтын салбарыг хөгжүүлсэн.
- Улаанбаатар хотын “Нэг тархи нэгдсэн систем” төслийг боловсруулан 2020-2024 онд хэрэгжүүлэхээр үндэсний мэдээллийн технологийн салбарын компаниудтай хамтран 2022-2024 онд хэрэгжүүлэхээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай санамж бичгийг байгуулсан.
- “Замын хөдөлгөөний зохицуулалт, төлөвлөлтийн нэгдсэн систем”, “Энхтайвны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээг зөрчил илрүүлэх камераар тоноглох”, “Нэгдсэн мэдээллийн систем, программ хангамж тоног төхөөрөмж нийлүүлэх” төслүүдийг Замын хөдөлгөөн удирдлагын төв, нийслэлийн Замын хөгжлийн газар, нийслэлийн Нийтийн тээврийн газар, ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн албадтай хамтран зохион байгуулж ажилласан.
- Нийслэлийн ойр орчмын шалган нэвтрүүлэх товчоодын төлбөрийг цахимжуулах хүрээнд Нийслэлийн Замын хөгжлийн газар, Авто тээврийн хөгжлийн төвүүдтэй хамтран нийслэлийн шалган нэвтрүүлэх 4 товчоодын төлбөр авах цэгийг цахимжуулсан.

Нийслэлд 2022-2024 онд хэрэгжүүлэх Зам, тээврийн нэгдсэн систем төслийн хүрээнд Улаанбаатар хотын 138 уулзварт радио давтамж тодорхойлох RFID төхөөрөмж суурилуулах ажилд хамтран ажиллах зорилгоор Сингапурын технологийн тэргүүлэх компани болох “Эс Ти Инженеринг” компанийн удирдлагын төлөөллийг нийслэлд хүлээн авч уулзаж зам, тээвэр, хот төлөвлөлттэй холбогдох чиг үүргийн байгууллагуудад ажиллаж төслийн эхний шатны судалгааг хийсэн. Судалгааны хүрээнд Улаанбаатар хотод тохирох зам, тээврийн технологийн шийдэл болон тоног төхөөрөмжийн үнийн саналыг ирүүлсэн. Энэ чиглэлд Улаанбаатар хот, Сингапурын “Эс Ти Инженеринг” компани хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан хамтран ажиллах чиглэлд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Мөн нийслэлд цахим шилжилттэй холбоотой төслийг хамтран хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах зорилгоор нийслэлд тулгамдаж буй төсөл, хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийг 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/06 дугаартайгаар байгуулсан.

Зам, тээврийн нэгдсэн ухаалаг систем төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олон улсын хотуудад хэрэгжүүлсэн туршлага, тоног төхөөрөмж нийлүүлж засвар, арчлалт, үйлчилгээг хариуцан ажилладаг олон улсын байгууллагуудын судалгааг хийсэн. Үүнд:

1. Сингапурын “Эс Ти Инженеринг” компанийн хэрэгжүүлсэн төслүүдийн мэдээлэл
2. Сингапурт төвтэй “Транскор” компанийн тоног төхөөрөмжийн мэдээлэл, үнийн судалгаа
3. Тайванд төвтэй “FETIC” компанийн хэрэгжүүлсэн төсөл, тоног төхөөрөмжийн мэдээлэл, үнийн судалгаа зэрэг судалгааг хийсэн.

5.2 Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл

Бодлогын баримт бичиг болох нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ хийх, гүйцэтгэлийн зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоон үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодитой мэдээллээр хангах хүрээнд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2, 6.3 дахь хэсгийн хяналт, шинжилгээ үнэлгээний аргачлалаар бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, Газрын даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох хэлтсийн дарга нарт үүрэг чиглэл өгч ажилласан. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэх нийт 5 арга хэмжээ, нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар тус тус нэгтгэн ажлын танилцуулга, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлийг тус тус бэлтгэн НЗДТГ-т албан тоотоор цаг хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. Дээрх бодлогын баримт бичигт тусгагдсан 15 арга хэмжээний хэрэгжилт 91% буюу гэж үнэлэгдсэн.
- Байгууллагын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 50 арга хэмжээний хагас, бүтэн жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн
- Байгууллагын хэмжээнд хяналтанд бүртгэлтэй 2022 оны хагас, бүтэн жилийн байдлаар дээд газрын тогтоол шийдвэр /Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 1, НИТХ-ын тогтоол 1 /-үүдийн хэрэгжилтийг улирал бүр нэгтгэн хяналт шинжилгээ үнэлгээ хийж газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулж холбогдох мэдээ тайланг НЗДТГ-т тухай бүр нь хүргүүлж ажилласан.

Байгууллагын 4 хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох хэлтсийн удирдлагуудад зөвлөмж өгч зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг өгч ажилласан.

5.3 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Байгууллагын хэмжээнд 2022 оны байдлаар нийт 22 өргөдөл гомдол, санал хүсэлт бүртгэгдсэнээ байгууллагад ирж байгаа санал хүсэлтийн дийлэнх нь Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Авто тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний www.smartcar.mn систем болон гар утасны аппликейшн ашиглан 3 төрлийн албан татвар, төлбөр төлөлт болон системээр үзүүлж буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой үйлчилгээ хэрхэн авах зааварчилгааг өгч ажиллаж байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP" системийг 1200 гаруй байгууллагын 32 мянга гаруй албан хаагчид ашигладаг бөгөөд системийн ачаалал тэр хэмжээгээр нэмэгдэж, хэрэглэгчийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ өсч, тусламж үйлчилгээг үзүүлэхэд ачаалал ихээхэн өссөн.

Системийн хэрэглэгчдэд техникийн дэмжлэг үзүүлэх, системийн ашиглалт, хэвийн тасралтгүй ажиллагааг хангах чиглэлээр систем ашиглалттай холбоотой өдөрт 80 гаруй дуудлага хүлээн авч утсаар зааварчилгаа, мэдээлэл өгөхөөс гадна системийн мессенжерт

ирсэн асуултуудад хариулж, зөвлөгөө өгч хэвийн ажиллагааг ханган ажиллаг байна.

Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч байгаатай холбоотой иргэдээс системийн ашиглалтын заавар зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан.

5.4 Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт

1.Хэрэглэгчдийг найдвартай, тасралтгүй, ухаалаг үйлчилгээгээр хангахын тулд мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, салбар бүрт хэрэгжих мэдээлэл технологийн асуудлыг бодлогын хүрээнд нэгтгэх, нэгдсэн удирдлагад оруулах.

2.Мэдээлэл технологийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчин, төсөв санхүү, хүний нөөцийн чадавхын асуудлыг дэмжих.

3.Байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулж мэдээлэл технологийн чиглэлийн чиг үүргийн хүрээнд нэгдсэн байдлаар зохион байгуулах, хөрөнгө оруулалтын ажлын давхцалыг арилгах

4.Шинээр үүссэн програм хангамж, системүүдийг ашиглах, хамгаалах, хөгжүүлэх, сайжруулах, нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмуудыг гаргахад хууль эрхзүйн тал дээр мэргэжлийн байгууллагын дэмжлэг, туслалцааг авч хамтран боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

О.ЧИНЗОРИГ

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЗУЛ